

Аудитын код: САГ-2018/7/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gungidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан
Утас : 261628 Цахим хаяг: javhlang@audit.gov.mn
Аудитор Ц.Цэрэнхүү
Утас: 261628 Цахим хаяг: tserenkhuuts@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	1
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	1
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	2
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	3
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	3
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	3
2.9.1	Зардлын талаар	3
2.9.2	Авлага, өглөгийн талаар	3
2.9.3	Дотоод хяналтын талаар	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	4
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	4
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	4
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	4
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	4
2.16	АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР	4
3	Менежментийн захидал	5
3.1	Зардлын талаар	6
3.2	Авлага, өглөгийн талаар	7
3.3	Дотоод хяналтын талаар	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ... Error! Bookmark not defined.	
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан Error! Bookmark not defined.	
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... Error! Bookmark not defined.	
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.... Error! Bookmark not defined.	
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан Error! Bookmark not defined.	
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..... Error! Bookmark not defined.	

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

1 Аудитын гэрчилгээ

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЦАГААНХҮҮ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ОРЛОГЧ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н. Цагаанхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 03 дугаар сарын 15-наас 2018 оны 03 дугаар сарын 21-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Ц.Цэрэнхүү нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 01/696 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан

“Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Улсын нутаг дэвсгэрт хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх эрх зүйн таатай орчныг бий болгох, хууль тогтоомж, стандарт хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг гол зорилгоо биелүүлэхэд үндсэн чиг үүргээ чиглүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Үйл ажиллагааныхаа зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай, Төрийн албаны тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай зэрэг хуулиудыг мөрдөж байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан. /ТАБ-СТА-А-1/

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/


Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан, түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Emerald” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй тодруулах, судлах зорилготой юм.



Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар урсгал зардалд 816.5 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын төсвийн захирагч нь 2017 онд урсгал зардалд 796.6 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 19.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансанд оруулах мэдээллээ хуулийн хугацаанд нь оруулж төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байгаа ба сар бүрийн төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээшхи гүйлгээ, 2017 оны батлагдсан төсөв, төсвийн тодотгол, хуваарь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэргийг мэдээллэж хэвшсэний гадна Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа 26 нэгж байгууллагын шилэн дансны хөтлөлтөд хяналт тавьж 2 удаа шалгалт хийн, илэрсэн зөрчлийг цахимаар мэдээллэн алдааг залруулж ажилласан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан /ТАБ-СТА-В-3/ маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно. Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Зардлын талаар

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч зардлын зүйл тус бүрээр хянагдах бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг 53.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.9.2 Авлага, өглөгийн талаар

Салбарын хэмжээнд авлага, өглөгийн хэмжээ жил бүр буурч байгаа боловч нэгтгэсэн тайлангаарх авлагын үлдэгдэл 50.9 сая, өглөгийн үлдэгдэл 26.4 сая төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах ажиллах талаар аудитын зөвлөмж өгөх;



2.9.3 Дотоод хяналтын талаар

МХЕГ-ын харьяа байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 94.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13.9 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 14.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 66.5 сая төгрөгийн 22 зөвлөмж өгч, Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албаны санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан тус байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох талаар албан шаардлага өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар нарийвчлан шалгах эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 130.9 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн ба уг алдаа зөрчилд 2 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу 2006 оноос хойш он дамжсан 29.4 сая төгрөгийн авлагын 50 хувийг барагдуулсан байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 35,937.6 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувиар буюу 718.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

2.16 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР

Аудитын явцад илэрсэн нийт 94.6 сая төгрөгийн алдаа зөрчлийн 63.0 сая төгрөгийн алдаа зарчлийг аудитын явцад залруулсан байна.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар батлагдсан төсвийг нийт дүнгээр хэтрүүлээгүй боловч зардлын зүйл тус бүрээр хянагдах бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг 53.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна. .

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай" хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн холбогдох заалт зөрчигдөх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.2 Авлага, өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Салбарын хэмжээнд авлага, өглөгийн хэмжээ жил бүр буурч байгаа боловч нэгтгэсэн тайлангаарх авлагын үлдэгдэл 50.9 сая, өглөгийн үлдэгдэл 26.4 сая төгрөг байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн холбогдох заалт зөрчигдөх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.

3.3 Дотоод хяналтын талаар

Тэргүүлэх ач холбогдол №3

ҮАГ-ын ажиглалт

МХЕГ-ын харьяа байгууллагуудын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 94.6 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрч, Сүхбаатар боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын алба” “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байна.

ҮАГ-ын зөвлөмж

Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулж, “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан тус байгууллагын холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож, биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн заалт зөрчигдөх, төсвийг үр ашиггүй зарцуулах,

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулсан болно.



4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган.төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,578,543.4	2,712,750.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	74,992.9	45,844.5
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	61,280.9	50,979.6
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,442,142.1	2,090,923.6
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	127.5	3.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		0.0	524,999.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		30,949,393.8	30,170,645.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	30,949,393.8	30,170,645.9
39100	Газар		0.0	0.0
39200	Биет хөрөнгө		30,937,198.8	29,893,067.0
39300	Биет бус хөрөнгө	13	12,195.0	277,578.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		33,527,937.2	32,883,396.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		143,227.5	26,375.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	143,227.5	26,375.6
41300	Өглөг	17а, 17б	77,727.5	10,875.6
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	65,500.0	15,500.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		33,384,709.7	32,857,020.7
51	Засгийн газрын хувь оролцоо		33,384,709.7	32,857,020.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		14,959,804.5	14,959,804.5
51200	Хуримтлагдсан үр дүн		16,814,908.6	16,327,233.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,609,996.6	1,569,983.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		33,527,937.2	32,883,396.3



4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код :	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		30,623,890.5	35,849,000.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	4,860,312.4	8,056,758.7
120	Нийтлэг татварын бус орлого		4,860,312.4	8,056,758.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		25,763,578.1	27,792,241.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	31,200,321.5	35,937,657.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ		31,200,321.5	35,917,657.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		27,242,458.6	29,940,318.9
210 1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		18,658,573.9	18,720,498.9
210 2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,966,314.4	2,067,386.2
210 3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,309,545.9	1,416,365.0
210 4	Хангамж, бараа материалын зардал		939,688.4	1,199,471.1
210 5	Нормативт зардал		515,185.3	483,599.6
210 6	Эд хогшил, урсгал засварын зардал		89,181.1	260,115.1
210 7	Томилолт, зочны зардал		232,132.9	406,335.2
210 8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		371,008.2	398,727.9
210 9	Бараа үйлчилгээний бусад зардал		3,160,828.6	4,987,820.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,957,862.9	5,977,339.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	20,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-576,431.0	-88,657.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		146,979.1	430,102.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-723,410.1	-518,760.1



4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
3	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	34,253,322.7	0.0	34,253,322.7
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-145,202.9	0.0	-145,202.9
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	34,108,119.8	0.0	34,108,119.8
9	Тайлант үеийн үр дүн	-723,410.1	0.0	-723,410.1
10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,384,709.7	0.0	33,384,709.7
11	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	33,384,709.7	0.0	33,384,709.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,398.7	0.0	-8,398.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	33,386,621.4	0.0	33,386,621.4
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-530.2	0.0	-530.2
18	Тайлант үеийн үр дүн	-518,760.1	0.0	-518,760.1
19	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	32,857,020.7	0.0	32,857,020.7



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2016оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	29,052,987.3	32,054,639.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,165,277.8	4,150,336.8
120	Нийтлэг татварын бус орлого	3,165,277.8	4,150,336.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,887,709.5	27,904,302.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,182,154.3	31,487,918.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,182,154.3	31,487,918.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,053,288.2	25,380,195.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,659,623.9	18,720,039.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,966,802.8	2,062,052.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,271,861.9	1,471,795.5
2104	Хангамж, бараа материалын зардал	747,050.4	857,903.9
2105	Нормативт зардал	518,055.0	568,681.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,206.8	241,757.2
2107	Томилолт, зочны зардал	234,908.2	412,803.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	463,395.2	509,917.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,383.8	535,244.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,128,866.1	6,107,722.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	870,833.0	566,721.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	803,489.1	595,869.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	803,489.1	595,869.7
2200	Дотоод эх үүсвэрээр	803,489.1	595,869.7
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-803,489.1	-595,869.7
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	67,343.9	-29,148.5
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,649.0	74,992.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	74,992.9	45,844.5

01


ТӨР АЖИРААНЫ БИЙГЭЭЛЭГ
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,145,460.7	26,983,481.9	161,978.8	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,650,260.7	26,488,282.8	161,977.9	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,826,340.7	24,725,371.6	100,969.1	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,779,430.1	18,719,468.6	59,961.5	99.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,062,937.1	2,062,052.4	884.7	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,487,400.7	1,471,795.5	15,605.2	99.0
2104	Хангамж, бараа материалын зардал	858,987.2	849,759.8	9,227.4	98.9
2105	Нормативт зардал	542,757.4	541,014.4	1,743.0	99.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	245,276.1	245,238.9	37.2	100.0
2107	Томилолт, зочны зардал	342,693.0	336,002.2	6,690.8	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	446,791.4	441,378.7	5,412.7	98.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,067.7	58,661.1	1,406.6	97.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,823,920.0	1,762,911.2	61,008.8	96.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,823,920.0	1,762,911.2	61,008.8	96.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	495,200.0	495,199.1	0.9	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	27,145,460.7	27,005,300.8	140,159.9	99.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,992,505.7	26,830,325.7	162,180.0	99.4
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	152,955.0	174,975.1	-22,020.1	114.4
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	211.2	-211.2	0.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	22,030.1	-22,030.1	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	27	27	0	100
610001	Төсвийн байгууллага	27	27	0	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2,008	2,008	0	100
620001	Удирдах ажилтан	34	35	1	103



Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

620002	Гүйцэтгэх ажилтан	1,521	1,501	20	99
620003	Үйлчлэх ажилтан	305	309	-4	101
620004	Гэрээт ажилтан	148	163	-15	110

